

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ
ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
СЯ 109 ТООТ ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ**

2017 оны 12 –р сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Сангийн Яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар, Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтийн хооронд 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан “Нягтлан бодох бүртгэлийн төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах” СЯ-109 тоот дугаартай гэрээний хүчин төгөлдөр хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Сангийн Яамны 2017 оны 12-р сарын 15-ны өдрийн гэрээ дүгнэсэн актыг үндэслэн гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэл гурван жилийн хугацаатайгаар сунгав.
- 1.2 Захиалагч ба гүйцэтгэгч талуудын 2016 оны 6 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан СЯ-109 тоот гэрээ, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, гэрээний хавсралтад заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ энэхүү гэрээний сунгалтын 1 дүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор гэрээг дүгнэсэн тэмдэглэлийг үйлдэж, гэрээг жил бүр дүгнэнэ.
- 1.3 Гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд 1 хувийг Сангийн яамны НБББГ, 1 хувийг ММНБ институт тус тус хадгална.
- 1.4 Гэрээнд тамга дарж, гарын үсэг зурснаар энэ гэрээ хүчин төгөлдөр болно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД:

МОНГОЛЫН МЭРГЭШСЭН НЯГТЛАН
БОДОГЧДЫН ИНСТИТУТИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)



ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ХАРИУЦАГЧ, ТӨРИЙН
САНГИЙН ДАРГА




/С.НАРАНЦОГТ/

МОНГОЛЫН МЭРГЭШСЭН НЯГТЛАН
БОДОГЧДЫН ИНСТИТУТИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ




/Л. ЭНХ-АМГАЛАН/

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА



/Г.ТҮВДЭНДОРЖ/

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН
БОДЛОГЫН ГАЗРЫН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН



/Д.ДАРИЙМАА/

*Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн
гудамж, Засгийн газрын II байр, Д корпус
утас:51-263069*

*Чингэлтэй дүүрэг 2-р хороо Их тойруу
өөрийн байр
Утас 317444 70111784*